



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 5/22

Ховд

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 48 дүгээр зүйлийн 48.1.2 дахь заалт, Монгол Улсын Сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 36, 32 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам”-ийн 5.1, 5.2 дахь заалт, аймгийн Онцгой комиссын хуралдааны 2021 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 44 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн “Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх вакцины хамралтыг эрчимжүүлэх тухай” 02 дугаар албан даалгаврын дагуу вакцинжуулалт хийхдээ ноцтой алдаа гаргаж ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн, онцгой нөхцөл байдлын үед ажлын хариуцлага алдсан \вакцинжуулалт хийхдээ 5 иргэнд өөр вакцин хийсэн\ тул Алтай сумын Засаг дарга Х.Түмэндэлгэрт 1 сарын хугацаанд үндсэн цалинг 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Эрүүл мэндийн газраас хүргүүлсэн мэдэгдэл болон вакцинжуулалт хийхдээ ноцтой алдаа гаргаж ажил үүргээ хангалтгүй биелүүлж, хариуцлагагүй хандсан Алтай сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмчид хариуцлага тооцож, ажлаас чөлөөлөхийг Алтай сумын Засаг дарга /Х.Түмэндэлгэр/-д үүрэг болгосугай.

3. Хууль тогтоомжоор хүлээсэн бүрэн эрхээ хэрэгжүүлж, үүрэг хариуцлага, ажлын үр дүнгээ сайжруулан, холбогдох албан тушаалтнуудаа мэргэжил, арга зүйгээр хангаж, дахин зөрчил, дутагдал гаргахгүй ажиллахыг Алтай сумын Засаг дарга /Х.Түмэндэлгэр/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

D/Zah-B/22-Bo